



# “ХУДАЛДАН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЧ” НҮТББ

2024 оны 01 сарын 19 өдөр

Улаанбаатар хот

## Сургалтын танилцуулга

Худалдан авах үйл ажиллагааны хөтөч” НҮТББ нь 2013 оны 12 сарын 02-ны өдөр байгуулагдсан бөгөөд 2016 оны 8 сарын 19-нд Монгол Улсын Сангийн яамтай Хамтран ажиллах ойлголцлын санамж бичгийг байгуулсан үеэс одоог хүртэл “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны хүний нөөцийг хөгжүүлэх” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллаж байна.

Энэ хөтөлбөрийн хүрээнд “Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх” суурь мэдлэг олгох /АЗ-3 өдөр/ танхимын болон танхимын бус сургалт, тендерийн үнэлгээний зөвлөх үйлчилгээ, хувийн хэвшилд зориулсан А1 буюу 1 өдрийн тендерийн сургалт болон тендер бэлтгэх зөвлөмж зэрэг сургалт, үйлчилгээг тогтмол үзүүлж байна. Тус байгууллагад дээрх сургалт, зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх бүхий мэргэшсэн, чадварлаг 2 сургагч багш болон худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн 2 ажилтан тус тус ажилладаг.

Танай байгууллагын хүсэлтээр “Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх” сургалтыг зохион байгуулахтай холбогдуулан “Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх сургалт эрхлэх байгууллага, түүний багш, ажилтанд тавигдах шаардлага, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр, шалгалтын журам”-ын хүрээнд батлагдсан сургалтын хөтөлбөр, хичээлийн агуулгыг хүргүүлж байна.

Манай байгууллага нь сургалт зохион байгуулах газар, өдөр, цагийн тухайд танай хүсэлтийг хүндэтгэн хүлээж авах болно.

Жич: Сургалт зохион байгуулах багш нар

№	Багшийн нэр	Ажил, мэргэжил	Ажлын туршлага
1	Н.Батжаргал	МУИС-ийн БС-ийн санхүүгийн тэнхимийн ахлах багш /Санхүү-Эдийн засагч/	2010 оноос засгийн газрын худалдан авах ажиллагааны АЗ сургалтын сургагч багш, МУИС-ийн Бизнес төвийн гэрээт багш, Дэлхийн банкны олон талт салбарын техник туслалцааны төслийн (P119825) засгийн газрын худалдан авах ажиллагааны сургалтын зөвлөх, Тогтвортой амьжиргаа-3 төслийн АЗ цахим сургалтын материал боловсруулах багийн зөвлөх, Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллага, бусад төрийн байгууллагын үнэлгээний хорооны хөндлөнгийн төлөөлөл (2012 оноос)
2	Н.Батболд	“ХАҮАХ” НҮТББ-ын сургагч багш /Нефтийн инженер/	2013 оноос засгийн газрын худалдан авах ажиллагааны АЗ сургалтын сургагч багш, Худалдан авах мэргэжлийн байгууллага, бусад төрийн байгууллагын үнэлгээний хорооны хөндлөнгийн төлөөлөл (2014 оноос)

ТЭРГҮҮН : ...../ Н.БАТЖАРГАЛ/



# “ХУДАЛДАН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЧ” НҮТББ

<b>Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалтын хөтөлбөр, агуулга</b>			
	<b>Сургалтын I өдөр</b>	<b>Сургалтын II өдөр</b>	<b>Сургалтын III өдөр</b>
09.00-10.20	Засгийн газрын худалдан авах ажиллагааны онолын үндэс, олон улсын стандарт, худалдан авах ажиллагааны процесс, эрх зүйн орчин	Тендер шалгаруулалт зохион байгуулах: Тендер шалгаруулалтын арга	Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам
10.20-10.30	Завсарлага	Завсарлага	Завсарлага
10.30-12.00	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн товч танилцуулга, нийтлэг үндэслэл	Худалдан авах ажиллагааны хяналт, зохицуулалт	Техникийн тодорхойлолт, Инкотермс
12.00-13.00	Их завсарлага	Их завсарлага	Их завсарлага
13.00-14.20	Худалдан авах ажиллагааны удирдлага, төлөвлөлт	Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшуулал	Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар, Захиалагч шийдвэр гаргах
14.20-14.30	Завсарлага	Завсарлага	Завсарлага
14.30-15.50	Худалдан авах ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, тайлагналт	Тендер шалгаруулалтын баримт бичиг боловсруулах Тендер шалгаруулалтын жишиг баримт бичгийн агуулга	Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам
15.50-16.00	Хэлэлцүүлэг	Хэлэлцүүлэг	Хэлэлцүүлэг